

**ХҮН АМЫН ХӨГЖИЛ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД,  
МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН  
ХАМТАРСАН ТУШААЛ**

2016 оны 3 дугаар сарын 04-ний өдөр

Дугаар А/32, А-64

Улаанбаатар хот

Орон сууцны ипотекийн  
зээлийн зарим нөхцөлийг тогтоох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь заалт, Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, “Ипотекийн зээл, санхүүжилтийн ерөнхий журам”-ын 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Засгийн газрын 2016 оны 3 дугаар сарын 4-ний өдрийн 137 дүгээр тогтоолоор баталсан “Ипотекийн зээл, санхүүжилтийн ерөнхий журам”-ын 1.2.1.а, 1.2.1.б, 1.2.2.а, 1.2.2.б-д заасан байршилд орон сууц худалдан авах тохиолдолд ипотекийн зээлийн жилийн хүүг 5 хувиар, 1.2.1.в-д заасан байршилд орон сууц худалдан авах тохиолдолд ипотекийн зээлийн жилийн хүүг 8 хувиар тус тус тогтоосугай.

2. Ипотекийн зээлээр худалдан авах нийтийн зориулалттай орон сууцны талбайн хэмжээг 80м<sup>2</sup>-аас ихгүй байхаар тогтоосугай.

3. Энэхүү тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн хамгааллын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Л.Мөнхзул), Монголбанкны Мөнгөний бодлогын газар (Д.Болдбаатар)-т тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар, Монголбанкны Дотоод хяналт, үйл ажиллагааны эрсдэлийн газар (Х.Дэлгэр) -т тус тус үүрэг болгосугай.

ХҮН АМЫН ХӨГЖИЛ, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН САЙД



МОНГОЛБАНКНЫ  
ЕРӨНХИЙЛӨГЧ

